



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 9/41

Жаргалтхаан

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 03 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд сумын төвийн нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид мод тарих ажилд зориулж тарьц, суулгац, бордоо худалдан авахад 1.340.000 (нэг сая гурван зуун дөчин мянган) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 1.340.000 (нэг сая гурван зуун дөчин мянган) төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас гаргаж, тайлагнахыг Нягтлан бодогч З.Жанчивт зөвшөөрсүгэй.

ДАРГА



Л.ЦЭНГЭЛ

Data (D:) /A4 zahiramj/

232401165